

**ЧӨЛӨӨТ БҮСЭД СОГТУУРУУЛАХ ҮНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, СУНГАХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, СЭРГЭЭХ,  
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь чөлөөт бүсэд согтууруулах үндаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл /цаашид “тусгай зөвшөөрөл” гэх-/ийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Чөлөөт бүсэд согтууруулах үндаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгоход Чөлөөт бүсийн тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Согтууруулах үндааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Зөвшөөрлийн тухай хууль зэрэг хууль тогтоомжийг удирдлага болгоно.

**Хоёр. Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага,  
бүрдүүлэх материал**

2.1. Согтууруулах үндаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг Зөвшөөрлийн тухай болон Чөлөөт бүсийн тухай хууль, энэхүү журмаар тогтоосон шаардлага, мэргэжлийн байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн чөлөөт бүсийн Захирагч олгоно.

2.2. Согтууруулах үндаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд нь худалдаа, үйлчилгээний технологи, ариун цэвэр, эрүүл ахуй, стандартын шаардлага хангасан байх бөгөөд хэрэглэгчдийн эрх ашгийг дээдэлсэн соёлтой үйлчилгээг үзүүлнэ.

2.3. Худалдааны газар нь “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019”, “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага” MNS 4946:2019” стандартад заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байх;

2.4. Тусгай зөвшөөрөл шинээр хүсэгч нь дараахь бичиг баримтыг бүрдүүлэн цахим үйлчилгээний нэгдсэн санд /E-Mongolia.mn/ болон Захирагчийн ажлын албанд ирүүлнэ.

2.4.1. Хүсэлт /эрхлэх үйл ажиллагааны чиглэл, ажилласан хугацаа зэргийг тодорхой дурдах/;

2.4.2.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон дүрмийн хуулбар;

2.4.3. Чөлөөт бүсийн бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.4.4. ААН-ийн дотоод хяналт шалгалтын журмын хуулбар;

2.4.5. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн бүртгэлд бүртгүүлсэн мэдээлэл;

2.4.6. Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагчийн дүгнэлт;

2.4.7. Цагдаагийн газрын хяналтын камерын тодорхойлолт; /60-аас доошгүй хоног дүрс бичлэг хадгалдаг, камерын халдашгүй байдлыг хангах/

2.4.8. Худалдаа, үйлчилгээ явуулах барилга байгууламж нь “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019” стандартын супер маркет буюу 201-501 м<sup>2</sup>-н, худалдааны төв дотор 100-150 м<sup>2</sup>-н хэмжээтэй байх бөгөөд гадна, дотно тохижилт болон аюулгүй байдлын шаардлага хангасныг харуулсан фото зураг; /Худалдаа, үйлчилгээ явуулах барилга байгууламжийн гадна талбайг тохижуулж, гэрэлтүүлэг, аюулгүй байдлын шаардлага хангасан гал хамгаалах болон дохиолол хамгаалалтын төхөөрөмж байрлуулсан байх/,

2.4.9. Үл хөдлөх эд хөрөнгийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.4.10. Нэмэгдсэн өртгийн албан татварын төлбөрийн баримт /Е-баримт/ олгох төхөөрөмж болон кассын машины гэрчилгээний хуулбар.

2.4.11. Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

2.4.12. Шаардлагатай тохиолдолд тусгай зөвшөөрөл хүсэгч нь энэ журмын 2.3-т заасан стандарт болон хуульд заасан бусад шаардлагыг хангаж байгаа эсэх талаар холбогдох мэргэжлийн байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгэх;

### **Гурав. Тусгай зөвшөөрөл олгох**

3.1. Захирагчийн Ажлын алба нь энэхүү журмын 2.4-т заасан тусгай зөвшөөрөл хүсэгчийн өргөдөл, хүсэлт, шаардлага хангасан бичиг баримтыг хулээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.2. Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмын 2.4-т заасан материалын бүрдүүлбэрийг зөвшөөрлийн нэгдсэн санд бүртгэж, зөвшөөрлийн код олгоно.

3.3. Чөлөөт бүсийн Захирагч нь энэхүү журмын 3.2-д заасны дагуу Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлийн кодыг үндэслэн ажлын 14 хоногийн дотор дараах шийдвэрийн аль нэгийг бичгээр гаргана.

3.2.1. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргах;

3.2.2. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан /2.4-т заасан материалын бүрдүүлбэр дутуу/ үндэслэлийг тодорхой зааж албан бичгээр хариу өгнө.

3.4. Захирагчийн ажлын албаны хариуцсан мэргэжилтэн тусгай зөвшөөрөл олгох шийдвэрийг үндэслэн үнэт цаасыг хэвлэн олгоно. Мөн шаардлага хангасан тохиолдолд цахим үйлчилгээний нэгдсэн сан /E-Mongolia.mn/-аас хэвлэгдэн гарна.

3.5. Тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгоно. Хугацааг сунгах тохиолдолд анх олгосон хугацаагаар сунгана.

3.6. Тусгай зөвшөөрөл олгох шийдвэрт худалдаа, үйлчилгээний цэгийн ажиллах цагийн хуваарь, гэрчилгээнд согтууруулах ундааны төрлийг заасан байна.

#### **Дөрөв. Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах**

4.1. Захирагчийн ажлын албанаас зөвшөөрлийн хугацаа дуусахаас 45 хоногийн өмнө түүнийг сунгуулах тухай мэдэгдэж, бүртгэл хөтөлнө.

4.2 Аж ахуйн нэгж нь тусгай зөвшөөрлийн хугацаа дуусах өдрөөс 30 хоногийн өмнө хугацаа сунгуулах тухай хүсэлтээ дараах материалыг бүрдүүлж ирүүлнэ. Үүнд:

4.2.1. Худалдааны газар нь “Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 5021-1:2019”, “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага” MNS 4946:2019 стандартад заасан шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан тухай үйл ажиллагааны тайлан,

4.2.2. Тусгай зөвшөөрөл явуулсан хугацааны бараа эргэлтийн мэдээ,

4.2.3. Худалдах, үйлчлэх согтууруулах ундааны гарал үүслийн мэдээлэл,

4.2.4. Гаалийн байгууллагатай цахим сүлжээнд холбогдсон тухай тодорхойлолт /кассын систем нь гаалийн хяналтын тухай хууль журмын дагуу шаардлага хангасан мэдээ мэдээллийг агуулсан байх /

4.3. Захирагчийн ажлын алба нь тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагыг хэрхэн биелүүлж ажилласан талаар дүгнэж, шаардлагатай тохиолдолд холбогдох байгууллагаас дүгнэлт гаргуулсны үндсэн дээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах талаарх хүсэлтийг чөлөөт бүсийн Захирагчид танилцуулна.

4.4. Чөлөөт бүсийн Захирагч нь ажлын 7 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

#### **Тав. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх**

5.1. Чөлөөт бүсийн захирагч болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон санал, дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр 3 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлнэ.

5.1.1 Зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

5.1.2 Хуульд заасан мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл буруу гаргасан;

5.1.3 Зөвшөөрөл олгосноос хойш хоёр жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон.

5.2. Энэхүү журмын 5.1-д заасан зөрчил арилсан тохиолдолд тусгай зөвшөөрөл сэргээх хүсэлтийг үндэслэн анх авсан зөвшөөрлийн үлдсэн хугацаагаар сэргээнэ.

#### **Зургаа. Дараахь тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох**

6.1. Тусгай зөвшөөрлийг хуульд заасан үндэслэл болон энэхүү журамд заасан үндэслэлээр чөлөөт бүсийн Захирагч хүчингүй болгоно.

6.1.1. Зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

6.1.2. Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;

6.1.3. Зөвшөөрөл эзэмшигч нийтийн эрх ашиг, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчин, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлсэн, их хэмжээний хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;

6.1.4. Зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, Гаалийн хууль тогтоомжийг жилд хоёр буюу түүнээс дээш удаа зөрчсөн;

6.1.5. Зөвшөөрөл, түүнийг баталгаажуулсан баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд худалдсан, бэлэглэсэн, барьцаалсан болон бусад хэлбэрээр шилжүүлсэн;

6.1.6. Зөвшөөрлийг авахдаа хурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

6.1.7. Зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд бол дампуурсан, эсхүл татан буугдсан;

6.1.8. Хууль, журамд зөвшөөрсөн хэмжээнээс ихээр худалдан борлуулсан нь эрх бүхийн байгууллага тогтоосон тохиолдолд;

6.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэлийг үл зөвшөөрсөн хуулийн этгээд нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу гомдлоо эрх бүхий байгууллагад гаргаж болно.

#### **Долоо. Зөвшөөрлийн бүртгэл мэдээллийн сан**

7.1 Тусгай зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг Зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлнэ.

#### **Найм. Худалдах, үйлчлэхэд хориглох тухай**

8.1. Зөвшөөрөгдсөн байршлаас буюу тухайн байр /танхим/-аас бусад газарт согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх;

8.2. энэхүү журмын 2.4.8.-д заасан шаардлагыг хангагүй бол;

8.3. Тусгай зөвшөөрлийн эрхийг бусдад худалдах, түрээслүүлэх, гэрчилгээг хувилж олшуруулах, өөр ажлын байранд шилжүүлэх, бусдад ашиглуулах,

8.4. Худалдааны газарт согтууруулах ундаагаар ил задгай үйлчлэх.

8.5. Согтууруулах ундаа худалдах түүгээр үйлчлэх тогтоосон цагийн хуваарийг зөрчиж, худалдаа, үйлчилгээ явуулах.

#### **Ес. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн нэгжийн хүлээх үүрэг**

9.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Улсын бүртгэлийн гэрчилгээ, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээ, бүтээгдэхүүн тус бүрийн шинжилгээний бичиг, улсын байцаагчийн дүгнэлт, бэлтгэн нийлүүлсэн газрын зарлагын баримт /тамга, гарын үсэгтэй байх/ зэрэг бичиг баримтын бүрдлийг байнга ханган шаардлагатай тохиолдолд эрх бүхий этгээдэд чирэгдэлгүй шалгуулна.

9.2.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хэрэглэгчдэд харагдахуйц газар байрлуулан, чөлөөт бүсийн Захирагчийн баталсан цагийн хуваарийг хатуу чанд мөрдөж ажиллана.

9.3.Зөвхөн стандарт, чанарын баталгаатай хүнсний бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч, зөв хадгалан “Цагаан болон өвөрмөц архи. Техникийн ерөнхий шаардлага MNS 0179:2016”, “Согтууруулах ундаа. Ликёр болон ликёрийн төрлийн архи. Техникийн ерөнхий шаардлага MNS 5984:2009” стандартад нийцсэн согтууруулах ундаагаар худалдаалж, үйлчилнэ.

9.4.Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж нь согтууруулах ундааны талаарх хориглосон болон далд сурталчилгааг явуулахыг хатуу хориглох бөгөөд Зар сурталчилгааны тухай болон Өрсөлдөөний хуулийг чанд баримтлана.

9.5.Суурилуулсан камерийг байнгын ажиллагаатай байлгана.

#### **Арав. Журмын хэрэгжилтэд хяналт тавих**

10.1.Энэ журмын хэрэгжилтэд чөлөөт бүсийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Захирагчийн ажлын алба хяналт тавьж ажиллана.

10.2.Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага ногдуулна.

---- оОо -----